

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Шадар сайдын ажлын алба / Онцгой байдлын асуудал эрхэлсэн /

АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮС 2026 оны эхний хагас жил

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ	Үнэлгээний тайлбар	Хяналтаас хасах саналтай эсэх	Хяналтаас хасах санал
МУ-ын хууль									
1	1	Чөлөөт бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-02-12 Дугаар 2015.02.12	Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар батална.	Барилга, хот байгуулалтын яамны сайдын 2022 оны А/10 дугаартай тушаалаар Алтанбулаг чөлөөт бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар сайдын багцаас 214.9 сая төгрөг төсөвлөгдөн Идеал групп ХХК болон Некст степ инженеринг ХХК-ийн түншлэл шалгарч 2022/304 дугаартай гэрээ байгуулсан. Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулах чиглэлээр гүйцэтгэгч байгууллагын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт удааширсантай холбогдуулан ажлыг эрчимжүүлэх, төлөвлөгөөний төслийг богино хугацаанд эцэслэн боловсруулж батлуулах, шаардлагатай тохиолдолд гэрээний хариуцлагын асуудлыг шийдвэрлүүлэх талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам захиалагчийн хяналт тавьж буй Барилга хөгжлийн төв ТӨҮГ-т албан бичгээр хандсан. Үүний дагуу холбогдох талуудын уулзалтыг зохион байгуулж, төслийг шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх чиглэл өгөгдсөн ч хэрэгжилт хангагдаагүй тул гэрээний асуудлыг шийдвэрлүүлэх саналыг захиалагч байгууллага Хот байгуулалт, барилга, орон	85%			Үгүй	
	2		7.1.Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7.1.9.чөлөөт бүсийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах;	Эдийн засаг, хөгжлийн яаман дээр 2023 онд Ажлын хэсэг байгуулан боловсруулсан “Чөлөөт бүсэд мөрдөх нийтлэг журам”-ын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Шадар сайдын ажлын албаны Ажлын хэсэгт цахимаар хүргүүлж ажилласан.	80%			Үгүй	
УИХ-ын тогтоол									

9	17	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39	Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллав. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, хариуцлагыг ханган ажилласан. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, шилэн дансны болон төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд ил тод мэдээлэн ажиллав.	100%			Үгүй	
	18		Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн дараа оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэх;	Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих, инженерийн дэд бүтэц болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал боловсруулж, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг үндэслэн эрэмбэлэн холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Тухайлбал, авто зам, инженерийн шугам сүлжээ, хяналтын систем, бизнес инкубатор төв зэрэг чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд шаардлагатай төсөл, арга хэмжээг 2027 оны улсын төсвийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлж, шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	100%			Үгүй	
15	26	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад хөтөлбөрийн	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг байгууллагын төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	100%			Үгүй	

17	29	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар. Ёс зүйн	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 12 дугаар зүйлийн 12.1.3, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг үндэслэн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулж, жил бүр төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%			Үгүй	
18	30	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2024-08-27 Дугаар 2024_21	3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 132, 133, 134, 538, 545, 546, 547 дугаар зорилт арга хэмжээний хэрэгжилт 2026 оны байдлаар дунджаар 20 орчим хувьтай байна. Авто замын шинэчилсэн зураг төсөл, магадлал, төсөв батлагдсан, ерөнхий төлөвлөгөө экспертизийн шатанд хүрсэн зэрэг суурь бэлтгэл ажлууд хангагдаж, төслийг дараагийн шатанд шилжүүлэх техникийн үндэс бүрдээд байна. Барилгын материалын логиستيкийн төв байгуулах суурь баримт бичиг боловсруулах 128.0 сая төгрөг, авто замын барилга угсралтын ажлын 71.16 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнчлэн холбогдох ТЭЗҮ, зураг төслийн зардал улсын төсөвт тусгагдаагүй, ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын төслүүдийн бодит хэрэгжилтийг хойшлуулах нөхцөл үүсгээд байна. Үүний улмаас шинэ төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа түр хугацаанд зогсоод байна. Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт хэлбэрээр шийдвэрлэх санал боловсруулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварын хүрээнд хэрэгжүүлэх	50%			Үгүй	
УИХ-ын байнгын хорооны тогтоол									
23	37	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр-ийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган улирал тутам тайлагнаж ажиллаж байна.	100%			Үгүй	

24	38	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-01-14 Дугаар 2025_01 ИЦБХХ	Төсвийн тухай хуулийн 28Т2.4, 291.3 заалтуудын хэрэгжилтийг хангуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаал “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах, цахим орчинд байршуулж буй төсвийн талаарх мэдээллийг эдгээр	Төсвийн тухай хууль болон холбогдох журам, аргачлалын хэрэгжилтийг ханган ажиллаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох шаардлага, загварт нийцүүлэн боловсруулж, цахим орчинд тухай бүр байршуулсан. Мөн төсвийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэн ажилласан.	100%			Үгүй	
	40	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ	З/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бүс, бие даасан	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр-ийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган улирал тутам тайлагнаж ажиллаж байна.	100%			Үгүй	
	41		1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох асуудлыг 2025 оноос эхлэн төсөвт суулгуулан улирал бүр урамшуулалыг олгож байна.	100%			Үгүй	
	43	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ТББХ	Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын гишүүдийн хараат бүс, бие даасан	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр-ийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган улирал тутам тайлагнаж ажиллаж байна.	100%			Үгүй	
	44		Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудаад: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын Ёс зүйн дэд	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох асуудлыг 2025 оноос эхлэн төсөвт суулгуулан улирал бүр урамшуулалыг олгож байна.	100%			Үгүй	

Ерөнхийлөгчийн зарлиг

ҮАБЗ-ийн зөвлөмж

	61	Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай 2013-01-08 Дугаар 2013_01/01	Гадаадын албаны болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй уулзахдаа: Гадаад харилцаа хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас яриа сэдэв гаргуулж, дээд шатны албан тушаалтнаас чиглэл авна.	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 17 дугаар хуралдаанд санал оруулж мөн уг хуралдааны Монголын Улсын бүрэлдэхүүнд орж хуралдаанд оролцсон. -Монгол Улс болон ОХУ-ын хоорондын бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Монгол-Оросын бүс нутгийн анхдугаар чуулга уулзалт”-нд 2025 оны 12 дугаар сарын 1–2-ны өдрүүдэд ОХУ-ын Эрхүү хотноо зохион байгуулагдаж, “Монгол, Оросын худалдаа, аж үйлдвэрийн хамтын ажиллагааны нөөц бололцоог ашиглах нь” нэгдүгээр салбар хуралдаанд Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас илтгэл тавьж, амжилттай оролцсон болно. -ШСАА болон ЭЗХЯ-нд илтгэх хуудас явуулсан. /Албан тоотууд: 01/388, 01/413/	100%			Үгүй	
	65		Уулзалтын явцад заавал ярианы тэмдэглэл хөтөлнө					Үгүй	
ЗГ-ын тогтоол									
52	95	Төсвийн хэмнэлтэд тооцох тухай 2025-06-20 Дугаар 2025_02	Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт болон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан боловч 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний дараах санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцож, хэмнэлтийг тухайн шатны төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ	Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах зарчмыг баримтлан ажиллав. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөн ажилласан бөгөөд худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг холбогдох журмын дагуу шийдвэрлэн ажиллав. Мөн хэрэгжээгүй болон гэрээ байгуулагдаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулж, төсвийн сахилга бат, хариуцлагыг ханган ажилласан.	100%			Үгүй	

62	115	Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2025-12-24 Дугаар 2025_226	Энэхүү тогтоолыг албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, зайлшгүй шаардлагатайгаас бусад сул орон тоонд албан хаагч нөхөж авахгүй байх, ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг цахимжуулах зэрэг арга хэмжээ	Засгийн газрын 2025 оны 226 дугаар тогтоолыг үндэслэн байгууллагын албан хаагчдын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн Алтанбулаг чөлөөт бүсийн 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар захирамжаар баталсан.	100%			Үгүй	
65	118	Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай 2026-01-14 Дугаар 2026_11	2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуягт үүрэг болгосугай.	“Алтанбулаг” чөлөөт бүсэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, дадлага, хяналт шалгалт зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу 2026.04.10 өдөр Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газартай хамтран дараах агуулгаар танхимын болон гадаах дадлагын үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: ☐ Гамшгаас хамгаалах хууль, тогтоомж ☐ Зөвлөмж, мэдээлэл ☐ Гал унтраах арга, практик дадлага Мөн үйл ажиллагаа эрхэлж байгаа 25 дэлгүүрээр Онцгой байдлын газрын шинжээчид болон ЗАА алба хаагчид хамтран үзлэг, шалгалтын ажлыг зохион байгууламж, зорьомж олж ажилласан.	100%			Үгүй	

70	126	Төсвийн хөрөнгө оруулалтын цахим шинэчлэлтийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2026-03-25 Дугаар 2026_103	1.8.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (pimis.publicinvestment.gov.mn)-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, өмчийн удирдлага, ашиглалтын үр өгөөжийг тооцох зэрэг үйл ажиллагааг ил тод, нээлттэй хэрэгжүүлэх нөхцөл бүрэн бүрдсэн тул төсвийн үр ашиг, хэмнэлтийн хүрээнд энэ чиглэлийн ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг төсвийн захирагч нарт.	Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх хүрээнд 1. Чөлөөт бүсийн доторх хүзүүвч 14.51 км хатуу хучилттай стандартын шаардлага хангасан авто замын барилга угсралтын ажилд 71,160.37 тэрбум төгрөг, 2. Чөлөөт бүс доторх 13.8 км авто зам болон чөлөөт бүсээс улсын хил хүртэлх 0.81 км авто замын борооны ус зайлуулах шугамын барилга угсралтын ажилд 5,022.08 тэрбум төгрөг, 3. Оросын Холбооны Улстай тусгай зориулалтын гарцтай холбох авто замын зураг төслийн ажилд 5,228.14 тэрбум төгрөг, 4. Барилгын материалын логистикийн төв байгуулах 3 га газарт ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажилд 128.0 сая төгрөг, 5. Бүсийн 12 га талбайд мэдээлэл теле хяналтын нэгдсэн системд холбох ажилд 553,90 сая төгрөгийн төсвийн саналыг тус тус боловсруулж, нийт 82,220.49 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2027 оны улсын төсөвт тусгуулахаар төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн pimis системд шаардлагад нийцүүлэн мэдээллийг нэгтгэж оруулсан.	100%			Үгүй	
73	130	Бизнесийн орчныг дэмжих зарим арга хэмжээний тухай 2026-04-15 Дугаар 2026_127	1.Иргэн, хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуульд заагаагүй боловч бусад хуулиар бүртгэл хийх шаардлагатай худалдаа, үйлчилгээг эрхлэх тухай мэдэгдлийг төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан бүртгэх, бүртгэлд шаардлагатай мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны системээс бүрдүүлэх, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зөвшөөрлийн нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх, үйл ажиллагааны онцлогоос	Иргэн аж ахуйн нэгжийн Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн үйл ажиллагааны албан хүсэлтийг www.e-business.mn-ээр нийт 5 удаа авч шийдвэрлэсэн. зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зөвшөөрлийн нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх ажлын хүрээнд license.mn-д холбогдон хөгжүүлэлтийг хийж байна.	100%			Үгүй	

	131		5.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг дэмжихээс бусад зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системийг шинээр хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө зарцуулахыг	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг дэмжихээс бусад зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системийг шинээр хөгжүүлээгүй болно.	100%			Үгүй	
Ерөнхий сайдын захирамж									
74	132	Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64	Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрандаа видео бичлэг тоглуулах дэлгэцийг байршуулан тогтмол цагт явуулж, мэдээлэл, ил тод байдлын самбар, санал хүсэлтийн хайрцагийг шинэчлэн байршуулсан.	100%			Үгүй	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл									

	135	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны	Оросын Холбооны Улсын нийслэл Москва хотноо 2024 оны 12 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 26 дугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөө хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, тус комиссын Монголын хэсгийн дарга С.Амарсайханд даалгав.	Оросын Холбооны Улсын Москва хотод болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 26 дугаар хуралдаанд санал бэлтгэл явуулсан. Мөн тус хуралдааны тоймлосон мэдээ боловсруулж бэлтгэн Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газарт явуулсан. -Дээрх 26 дугаар хуралдааны протокол, Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 16 дугаар хуралдааны протоколуудад Алтанбулаг чөлөөт бүсээс бэлтгэн явуулсан саналын дагуу: 1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд “Алтанбулаг” чөлөөт бүсийн хилийн чанад руу чиглэсэн гадаад гарц/орц/ нээх асуудлыг судлан танилцуулах хамтарсан Ажлын хэсгийг байгуулах” тухай Шадар сайдын Ажлын алба, Боомтын Сэргэлтийн Үндэсний Хороо руу хүсэлт, удирдамжийн төслийг боловсруулж илгээн, Ажлын хэсэг байгуулагдсан. -Ажлын хэсгийн хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхишиг, Гадаад	100%			Үгүй	
--	-----	--	--	--	------	--	--	------	--

	136	дугаар хуралдааны тэмдэглэл 2025-01-29 Дугаар 2025_06	“Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 132, 133, 134, 538, 545, 546, 547 дугаар зорилт арга хэмжээний хэрэгжилт 2026 оны байдлаар дунджаар 20 орчим хувьтай байна. Авто замын шинэчилсэн зураг төсөл, магадлал, төсөв батлагдсан, ерөнхий төлөвлөгөө экспертизийн шатанд хүрсэн зэрэг суурь бэлтгэл ажлууд хангагдаж, төслийг дараагийн шатанд шилжүүлэх техникийн үндэс бүрдээд байна. Барилгын материалын логиستيкийн төв байгуулах суурь баримт бичиг боловсруулах 128.0 сая төгрөг, авто замын барилга угсралтын ажлын 71.16 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнчлэн холбогдох ТЭЗҮ, зураг төслийн зардал улсын төсөвт тусгагдаагүй, ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын төслүүдийн бодит хэрэгжилтийг хойшлуулах нөхцөл үүсгээд байна. Үүний улмаас шинэ төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа түр хугацаанд зогсоод байна. Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт хэлбэрээр шийдвэрлэх санал боловсруулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварын хүрээнд хэрэгжүүлэх	50%			Үгүй	
79	138	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-28 Дугаар 2025_25	2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, дүнг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын Хяналт	2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан байгууллагын хэрэгжүүлж буй зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хэрэгжилт хангалтгүй болон удаашралтай байгаа ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж, үр дүнг сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.	100%			Үгүй	

	156	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16	1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгав: 1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах; 1.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах;	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулах болон хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангаж ажилласан. Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулан үнэлгээ хийж, үр дүнг үнэн зөв тайлагнан ажилласан. Мөн хэрэгжилтийг хангахад шаардлагатай асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.	100%			Үгүй	
	157							Үгүй	
	158							Үгүй	
	159		шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллаагүй байгууллага, албан тушаалтанд хууль, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.	Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь өөрийн эрхлэх чиг үүргийн дагуу үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав. 2026 оны I улиралд Шилэн мэдээллийн сан буюу shilen.gov.mn сайтын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 99.01 хувиар үнэлүүлж, холбогдох тайлан, мэдээллээ хуулийн хугацаанд багтаан үнэн зөв, бүрэн гүйцэт илгээж байна. Тайлант хугацаанд зөрчил гаргасан албан хаагч байхгүй	100%			Үгүй	

89	161	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-24 Дугаар 2025_18	1.хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжил, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд холбогдох төрийн байгууллага, хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдтэй уулзалт, зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавин ажилласан. Мөн хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх талаар Шадар сайдын ажлын албанд санал хүргүүлж, хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулан ажилласан.	100%			Үгүй	
	162		11.2.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг төлөвлөсөн	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Алтанбулаг чөлөөт бүстэй холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавин, төлөвлөсөн арга хэмжээг батлагдсан хугацаанд хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.	100%			Үгүй	
91		Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-08 Дугаар 2025_20						Үгүй	
	166		3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх.	Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах бүртгэлийн гэрчилгээ дараах үйлчилгээг хуулийн этгээдэд цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан үзүүлж байна	100%			Үгүй	

93	169	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-11-05 Дугаар 2025_26	1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээг авахыг даалгав: 1.1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр, “Нийгмийн шударга ёсыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар, “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар, Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 04 дүгээр албан даалгавраар хугацаатай өгсөн үүргийн хэрэгжилтийг 2025 оны 6 сараас эхлэн сар бүр тайлагнаж ажиллаж байна.	100%			Үгүй	
	171		3.“Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан яамд таван жилийн салбарын хөгжлийн төлөвлөгөөнд туссан бодлогын өөрчлөлтийн талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа үйлдвэрлэж, цахим хэрэгжүүлэх ажлын хүрээнд яам, Засгийн газрын агентлагууд иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11	100%			Үгүй	
	172		Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд яам, Засгийн газрын агентлагууд иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11	100%			Үгүй	

	173		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав;	Алтанбулаг чөлөөт бүс 2026 оны 1 ээс 5 дугаар сарын төсвийн урсгал зардлын гүйцэтгэл. Цалин, урамшуулал ,унаа, хоол, татвар , НДШ Батлагдсан төсөв 777,2 сая төгрөг Зарцуулалт 559.8 сая төгрөг Хэмнэлт 217.4 сая төгрөг Хувь 28 % Бусад зардлууд тайлант хугацаанд төсвийн хуваарь батлагдаагүй болно. Тайлант хугацаанд байгууллагын 64 ажил гүйлгээг Шилэн дансны мэдээлэл хуулийн хугацаанд нь оруулсан.	100%			Үгүй	
94	174	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-12-03 Дугаар 2025_30	Үүнтэй холбогдуулан 1.Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгав: 1.1.төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийн төрөлжсөн	Алтанбулаг чөлөөт бүс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын umch.gov.mn шинэчлэгдсэн цахим системд байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгүүдийг хуучин программтай тулгалт хийн оруулсан.	100%			Үгүй	
	175		1.2.эзэмшил, ашиглалтад байгаа эд хөрөнгө, хөрөнгө оруулалт, компанийн засаглал, үйл ажиллагаатай холбогдох шийдвэр, хяналт шалгалт, гүйцэтгэлийн тайлан, хуулиар нийтэд нээлттэй мэдээлэхээр	Алтанбулаг чөлөөт бүс https://shilendans.gov.mn хуулиар нийтэд нээлттэй мэдээлэхээр заасан бүх төрлийн мэдээллийг нэгдсэн цахим системд тухай бүр мэдээлэн ажиллаж байна.	100%			Үгүй	
	176		1.3.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, хуулийн этгээдийн бүртгэл, автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, санхүүгийн тайлан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүртгэл зэрэг төрөлжсөн мэдээллийн сангуудыг төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системд нэгтгэж, улмаар албан ёсны статистикийн мэдээлэлд нэгтгүүлж хэвшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Алтанбулаг чөлөөт бүс газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болох egazar.gov.mn-ээр ААН-ийн хүсэлтийн дагуу газрын хугацаа сунгах болон эрх шилжүүлэх ажлыг ханган ажилласан. Тайлант оны хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайланг Цахим санхүүгийн тайлангын систем болох e-balance.mn-ээр тайлагнаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүртгэлийг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем болох https://pimis.publicinvestment.gov.mn/ -ийг ашиглаж байна.	100%			Үгүй	

184	2.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасан зорилго, зорилтыг байгууллагын стратеги төлөвлөгөө болон төрийн захиргааны байгууллага, албан хаагчийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах	Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Алтанбулаг чөлөөт бүсийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, чөлөөт бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, хил, гаалийн үйл ажиллагааг сайжруулах, бизнесийн орчныг дэмжих чиглэлээр зорилт, арга хэмжээг тусган батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%			Үгүй	
185	3.Байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилт, зорилго нь төрийн захиргааны байгууллагын болон албан хаагчийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээтэй уялдсан байх, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийн түвшин нь хэмжигдэхүйц, тоон ба	Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Алтанбулаг чөлөөт бүсийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, чөлөөт бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, хил, гаалийн үйл ажиллагааг сайжруулах, бизнесийн орчныг дэмжих чиглэлээр зорилт, арга хэмжээг тусган батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	50%			Үгүй	
187	5.Төрийн аудитын байгууллагаас төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангаж, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн хэрэгжилтийг тайлагнахал хариуцагатай	Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын хэрэгжилтийг хуульд заасан хугацаанд бүрэн хангаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилган ажиллаж байна. Төсвийн хэрэгжилтийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгаж, Шилэн дансны цахим систем болон fas.audit.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь тайлагнаж байна.	100%			Үгүй	
189	1.Салбарын хэмжээнд үзүүлж байгаа төрийн цахим үйлчилгээний жагсаалтыг 2026 оны 02 дугаар сард багтаан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлэхийг Засгийн газрын	Алтанбулаг чөлөөт бүсийн хэмжээнд үзүүлж байгаа төрийн цахим үйлчилгээний жагсаалтыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлэх бэлтгэл ажил ханган ажиллаж байна.	50%			Үгүй	

99	190	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-01-21 Дугаар 2026_03	Улаанбаатар хотноо 2025 оны 12 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 27 дугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, тус комиссын Монголын хэсгийн дарга Х.Ганхуягт даалгав.	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 27 дугаар хуралдааны протокол, мөн Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын 17 дугаар хуралдааны протоколд “Алтанбулаг” чөлөөт бүсээс хүргүүлсэн саналын дагуу Монголын тал ОХУ-аас “Алтанбулаг” чөлөөт бүс рүү нэвтрэх, гарах тусгай зурвас байгуулахтай холбоотой хоёр талын схем зургийг боловсруулах хүсэлт гаргасан. Уг схем зургийн төслийг Комиссын Оросын хэсгийн Нарийн бичгийн дарга нарын газарт 2026 онд хүргүүлэхээр тусгагдсан болно. - Энэ хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр “Алтанбулаг” чөлөөт бүсээс ОХУ руу чиглэсэн тусгай орц, гарцыг холбох авто замын зураглалыг холбогдох мэргэжлийн байгууллагууд болох Гаалийн ерөнхий газар, Хилийн боомтын захиргаа, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын	100%			Үгүй	
	191	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-01-21 Дугаар 2026_03	1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;	Алтанбулаг чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын ажил нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8.1.7 дугаар зорилтын хүрээнд хэрэгжиж байна. 2026 оны байдлаар дэд бүтцийн ажлын нийт гүйцэтгэл ойролцоогоор 20 хувьтай байна. Гаалийн хяналтын талбайн бүтээн байгуулалт хийгдсэн боловч инженерийн шугам сүлжээ, авто зам зэрэг үндсэн дэд бүтцийн ажлууд эхлээгүй байна. Төсвийн санхүүжилтийн тасалдал, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын оролцоо сул байгаа зэрэг шалтгааны улмаас барилга байгууламжийг иж бүрэн ашиглалтад оруулах үйл явц удаашралтай байна. Иймд нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, менежментийн тогтолцоог шинэчлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх шаардлага үүссэн ба гадаадын донор байгууллагуудаас хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ авах, хамтын ажиллагааны	50%			Үгүй	

100	192	газрын 2026 оны 01 дүгээр сарын 28 ний өдрийн 04 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-01-28 Дугаар 2026_04	2.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн гүйцэтгэлийн тайланг бүрэн гүйцэд гаргаж, 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.	г Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 132, 133, 134, 538, 545, 546, 547 дугаар зорилт арга хэмжээний хэрэгжилт 2026 оны байдлаар дунджаар 20 орчим хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт хэлбэрээр шийдвэрлэх санал боловсруулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварын хүрээнд хэрэгжүүлэх боломжийг судлан, холбогдох байгууллагуудтай уялдуулах, хөрөнгө оруулагчидтай урьдчилсан уулзалт хийх зэрэг бэлтгэл ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа талаар тайлан мэдээг нэгтгэн хүргүүлсэн.	50%			Үгүй	
	193		4.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг аймаг нийслэлийн	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Алтанбулаг чөлөөт бүстэй холбоотой зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн, биелэлтийг тогтмол тайлагнан ажилласан.				Үгүй	
106	212	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаао сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл 2026-03-25 Дугаар 2026_11	Төрийн байгууллага, хувийн хэвшил хэмнэлтийн горимд шилжих, төсвийн зардлыг хэтрүүлэхгүй байх, сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов: 1.1.төсвийн сахилга батыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжих, төсвийн хэмнэлт гаргах замаар нэмэлт санхүүжилтийн хэрэгжүүлэх хэмжээг	Алтанбулаг чөлөөт бүс 2026 оны 1 ээс 5 дугаар сарын төсвийн урсгал зардлын гүйцэтгэл. Цалин, урамшуулал ,унаа, хоол, татвар , НДШ Батлагдсан төсөв 777,2 сая төгрөг Зарцуулалт 559.8 сая төгрөг Хэмнэлт 217.4 сая төгрөг Хувь 28 % Бусад зардлууд тайлант хугацаанд төсвийн хуваарь батлагдаагүй болно. Тайлант хугацаанд байгууллагын 64 ажил гүйлгээг Шилэн дансны мэдээлэл хуулийн хугацаанд нь оруулсан.	100%			Үгүй	

110	219	Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах “Хариуцлагатай шуурхай алба"	3.Эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хариуцлагатай шуурхай алба"-ыг байгуулж, нэгдсэн удирдлага, мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт	"Баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай" Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/10 дугаар захирамж баталсан.	100%			Үгүй	
	220	“Хариуцлагатай шуурхай алба" ажиллуулах тухай 2026-02-11 Дугаар 2026_01	4.Албан даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, аюул, осол, онцгой нөхцөл байдлын мэдээллийг	Тус хугацаанд Алтанбулаг чөлөөт бүс дээр аюул, осол, зөрчил гараагүй бөгөөд мэдээг Засгийн газрын Шуурхай албанд 2 цаг тутамд хүргүүлж ажилласан.	100%			Үгүй	
111	221	Төрийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2026-02-11 Дугаар 2026_02	1.1.Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1.1.иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж байгаа үйлчилгээг оновчилж, хүсэлт шийдвэрлэлтийн явцыг тухай бүр иргэн, хуулийн этгээдэд эргэн мэдэгдэх нөхцөлийг бүрдүүлэх;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг ил тод, нээлттэй байлгаж, цахим хуудсаар дамжуулан иргэд мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн ханган, мэдээллийг тухай бүр шинэчилж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсанд байгууллагыг нэгтгэж, мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн, https://www.gov.mn/org/altanbulagchulu хуудсаар үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийг шууд авч цахим хуудасны бэлэн байдлыг ханган ажиллаж байна.	100%			Үгүй	
	224		1.1.4.төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд хүргэхдээ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ийг ашиглах, ижил зорилготой мэдээллийн систем, гар утасны аппликейшныг тус системд нэгтгэх.	Хуулийн этгээдэд зориулсан төрийн үйлчилгээний цахим систем болох www.e-business.mn -ээр 2026 оны эхний хагас жилийн байдлаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийн албан хүсэлт нийт 12 удаа, Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах бүртгэлийн хүсэлт нийт 5 удаа тус тус хүлээн авч шийдвэрлэсэн.	100%			Үгүй	
	231		3.1.Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, бүсчилсэн хөгжлийн талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Чөлөөт бүсийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 96-р тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж тус ажлын хүрээнд зохих саналуудаа тухай бүр хэрэгжүүлсэн.	100%			Үгүй	

114	235	Бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2026-04-08 Дугаар 2026_06	3.5.Бүсүүдэд хөрөнгө оруулалт татах, бүсийн удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог оновчтой болгох зорилгоор Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	Алтанбулаг чөлөөт бүсэд шинээр төсөл, бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх сонирхолтой дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулсан. Төсөл хэрэгжүүлэх сонирхол бүхий дотоодын аж ахуйн нэгжүүд гадаадын түнш байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 4, Оросын Холбооны Улсын 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 3, нийт 8 аж ахуйн нэгжээс 35 га газарт логистик, худалдаа, аялал жуулчлал, мах боловсруулах үйлдвэр, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн үйлдвэр, капсул хаус, агуулахын чиглэлээр төсөл хэрэгжүүлэх санал ирүүлснийг нэгтгэн шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.	50%			Үгүй	
-----	-----	--	--	---	-----	--	--	------	--

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал